

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 1, 2 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 03 дугаар сарын 06

Улаанбаатар хот

Дугаар	ХБТББ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая төг)	Төсвийн гүйцэтгэл (сая төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	4.3.9. Гадаадын иргэн, харьяа лалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно	1. Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авах дэвшилтэд систем /APP/-ийг нэвтрүүлэх, зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авч боловсруулалт хийх, хариу мэдээлэх мэдээллийн төвийг байгуулна.	2020-2024	Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар	Төр, хувийн хэвшлийн түншлэл	2,277.2	Гэрээний төслийг бэлдэж, урьдчилан тохиролцсон байна.	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	583.2	-	Киргизийн зорчигчийн мэдээллийн төвтэй танилцах зорилгоор 02 дугаар сарын 15-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан арга хэмжээнд тус байгууллагаас төлөөлөл оролцлоо. Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан тус арга хэмжээний үндсэн	-

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
											<p>хэрэгжүүлэгч байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, хамтрагч байгууллага нь Боомтын үндэсний зөвлөл, оролцогч байгууллага нь Иргэний нисэхийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар байна. Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 261 дүгээр тогтоолоор НҮБ-ын "Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр /goTravel/-ийг хэрэгжүүлэх, мөн энэ талаар авах зарим арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, хөтөлбөрийг зохицуулагч байгууллагаар Хил хамгаалах ерөнхий</p>	

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
											газар, үндэсний зохицуулагчийн чиг үүргийг Терроризмтой тэмцэх зөвлөлийн Ажлын албанд хариуцуулсан тул Гадаадын иргэн, харьяатын газрын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний хяналтаас хасуулах саналтай байна.	
2	4.3.9. Гадаадын иргэн, харьяа лалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно	2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	2021-2024	Хууль зүй, дотоод хэргийн яам	Улсын төсөв	772.0	-	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	-	-	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийг хэрэгжүүлэх асуудлаар 01 дүгээр сарын 03-ны өдөр “Аствишн” ХХК-тай уулзалт зохион байгуулж, туршилтын “Хувилбар 01”-ээс тодорхой хэсгийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх хугацааг шинэчлэхээр тохиролцсон. Үүний дагуу 01 дүгээр сарын 18-ны өдрийн цахим хурлаар үйл ажиллагаанд нэвтрүүлэх хугацааг хойшлуулж, туршилтын нэгдүгээр	30

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
											хувилбартай 02 дугаар сарын 14-ний өдөр, хоёрдугаар хувилбартай 02 дугаар сарын 20-ны өдөр тус тус танилцан системийн тестийг туршсан бөгөөд үйл ажиллагаанд нэвтрүүлж эхлээгүй байна.	

--oo0oo--